



БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Ойдов
Утас: 261885
Цахим хаяг: oidovts@audit.gov.mn

Аудитор: Ж.Болормаа
Утас: 260512
Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn
2016 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

*Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан*

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2016/8/САГ-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 25-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын аудитор

Ж.Болормаа гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд тус яамны аппаратын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Барилга хот байгуулалтын яам нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд,

- 2015 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын засгийн газрын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Архивын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Авилгатай тэмцэх тухай хууль - Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын тухай хуулиуд зэрэг байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын хот, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоог бүрдүүлж, нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг бий болгох, Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Төрөөс газрын харилцааны талаар баримтлах бодлого, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, Монгол орны нутаг дэвсгэрийг зурагжуулах, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоог хангах, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулахад тус Яамны зорилго оршино.

Яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажилладаг байна. Үүнд,

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх;

- Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Төрийн захиргаа, хүний нөөц, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдлагаар хангах.

Дээрх зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Яамны Төрийн нарийн бичгийн дарга нь Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тус яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдаас түүвэрлэн аудитын нарийвчилсан горим, сорил 25-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажилласан байна.

Яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “ACOLOUS” програмаар боловсруулж байна.

Мөн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн байна. /ТАБ-СТА-В-2/

Яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлоын 1% буюу 23.8 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Зохицуулах зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “ дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт сул байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Тус яамны аппаратын 2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Аппаратын 2015 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвийн санхүүжилтийн орлого 2,510.7 сая төгрөг батлагдсанаас 2,351.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 2,354.9 сая төгрөгийг зарцуулж 2,688.6 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Төсвийн санхүүжилтийн орлогоос гадна нэмэлт санхүүжилт 4.6 сая, төсвийн урамшуулал 0.8 сая, туслах үйл ажиллагааны орлого 0.7 сая нийт 6.1 сая төгрөгийн орлого тайлагнагдсан байна.

Зардлын эдийн засгийн ангиллаар Гадаад албан томилолт 5.5 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтэрсэн боловч эдийн засгийн бүлгийн дүнгээр төсвөөс хэтэрсэн зардал байхгүй байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Яамны аппарат нь Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны “ Журам батлах тухай” 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн wsrc.gov.mn веб сайтад Шилэн данс цэсийг байршуулж дараах мэдээллийг оруулсан байна. Үүнд,

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 785.3 сая төгрөгийн 28 гүйлгээ, түүний дотор Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн ТХН болон Замын үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн санхүүжилтийн гүйлгээнүүдийг оруулсан байна.

Гэвч байгууллагын веб сайтын Шилэн данс цэс одоогийн байдлаар ажиллахгүй байгаа бөгөөд шилэн дансанд тавигдах мэдээллүүдийг бүрэн оруулаагүй, шилэн дансанд тавьсан мэдээлэл хангалтгүй байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 30 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов.

- 2015 оны санхүүгийн тайлангийн касс, харилцахын гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд 4.4 сая төгрөгийн анхан шатны баримтгүй гүйлгээ, ажил гүйцэтгэх гэрээгүй, ажил хүлээлцсэн актгүй 5.0 сая төгрөгийн гүйлгээ, кассаас гарсан бэлэн мөнгөний 18.8 сая төгрөгийн зардлын гүйлгээний анхан шатны баримт дутуу буюу хүчин төгөлдөр бус,
- Томилолтын зардлуудын анхан шатны баримтын бүрдэл дутуу, хуурамч баримт үйлдсэн, томилолтоор ажилласан тайлан, томилолтын хуудас зэрэг баримт бүрдүүлээгүй нийтлэг алдаа зөрчил илэрсэн учир Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмжийг өгөв.

Дээрх зөрчлүүд нь санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, бэлэн мөнгө хүлээн авсан хүмүүс нь баримтаа бүрдүүлж өгч хэвшээгүй бөгөөд санхүүгийн холбогдох ажилтнуудын хариуцлага муу байгаатай холбоотой байна.

Ес. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа үйлчилгээний орлого, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБСТА-В-3/

Тайлант жилд гарсан онцлог гүйлгээг дурдвал:

- Засгийн газрын 2014 оны “Яамдын зохион байгуулалтын бүтцийн тухай” 382 дугаар тогтоолоор тус яамны орон тооны дээд хязгаарыг 64 байхаар баталсан байна. Үүний дагуу ТНБД-ын 2015 оны 1 сарын 23-ны өдрийн 6 дугаар тушаалаар Яамны албан хаагчдын 58 орон тоо

баталсан боловч гэрээт 5, үндсэн ажилтан 11 хүн нэмж ажилд авч 107.4 сая төгрөгийн цалин олгосон байна.

- Яамны сайд өөрчлөгдөж, дэд сайдын орон тоо хасагдсантай холбоотой ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн болон бүтцийн өөрчлөлтд орсон ажилтнуудад 2015 онд нийт 80.6 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил болон удирдлагын анхаарал хандуулах гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. 2015 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй бөгөөд Санхүүгийн байдлын тайланд Бараа материалын дүн 5.0 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дүн 1.2 сая төгрөгөөр, хуримтлагдсан элэгдэл 2.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

2. Норм, нормативын сангийн санхүүжилтийг Сангийн яамнаас БХБЯ-аар дамжуулж Барилгын хөгжлийн төвд шилжүүлдэг бөгөөд 2015 онд 231.4 сая төгрөгийн зардлын тооцоо нэмж үүссэн боловч жилийн санхүүгийн тайлан гарахаас өмнө тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн санхүүгийн тайлан гарахад тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах зөвлөмжийг өгөв.

3. 2015 оны Төсвийн тухай хуулиар БХБЯ нь улсын төсөвт 1,200.0 сая төгрөгийн Норм, нормативын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч 1,010.3 сая төгрөг буюу 84%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төлөвлөгөөг биелүүлж ажиллах зөвлөмжийг асуудлын бүртгэлд тусгав.

4. Техник хяналтын зардлын 900029301 дугаар данснаас 47.2 сая төгрөгийн зардал гарснаас анхан шатны баримтын бүрдэлгүй 27.0 сая төгрөгийг Барилгын хөгжлийн төв руу Техник хяналтын зардал нэрээр 2015 оны 12 дугаар сарын 11-нд шилжүүлж зардлаар бүртгэсэн байна. Барилгын хөгжлийн төвөөс баримтыг татаж үзэхэд 16.9 сая төгрөгийн томилолтын баримт бүрдүүлж 10.1 сая төгрөгийг өглөгөөр бүртгэсэн боловч томилолтоор ажилласан тайлан, томилолтын хуудас зэрэг

анхан шатны баримт бүрдүүлээгүй, тушаалд нэр заасан бүрэлдэхүүнээс 3 хүн яваагүй болохыг аудитын явцад тогтоов.

Мөн тус данснаас гарсан бусад томилолтын зардлын анхан шатны баримтыг шалгаж үзэхэд 1.2 сая төгрөгийн хүчин төгөлдөр бус баримт бүрдүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа тул Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5. Барилга хот байгуулалтын сайдын гарын үсэгтэй албан бичгээр Барилгын хөгжлийн төвөөс 43.0 сая төгрөгийн томилолтын зардал гарсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайланд залруулагдаагүй материаллаг алдаа гараагүй байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Барилгын норм, норматив боловсруулах сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөг улсын төсөвт төвлөрүүлсэн орлогод тааруулан боловсруулж байгаа нь учир дутагдалтай байна.

Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 Барилгын норм, нормативыг боловсруулах сангийн хөрөнгийг норм, нормативын бичиг баримтыг боловсруулах, шинэчлэх зорилгоор зарцуулна гэж заасан боловч БХБСайдын 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 108 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журам" -д сангийн хөрөнгийг зарцуулах арга хэмжээний хамрах хүрээг хуульд зааснаас өргөн болгосон нь зардал нэмэгдэх үндэс болсон байна.

Барилгын норм нормативын сангаас 2015 онд нийт 332.2 сая төгрөгийн зардал гарснаас 77.7 сая төгрөгийг БХБЯ-ны үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар Барилгын норм, нормативыг боловсруулах сангийн үйл ажиллагааг нарийвчлан шалгаж амжаагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 308.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 8.6 сая төгрөгийн алдааг залруулж 28.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 271.5 сая төгрөгийн зөрчилд асуудлын бүртгэлээр болон менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2014 оны санхүүгийн тайланд УАГ аудит хийж 6 зөвлөмж өгсөн бөгөөд 5 зөвлөмжийг биелүүлж Балансад бүртгэлтэй 2 автомашины асуудлыг ТӨХ-гоор шийдвэрлүүлэх гэсэн 1 зөвлөмжийг биелүүлж ажиллаагүй байна.

Арван зургаа. Зөвлөмж

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгч менежментийн захидлыг хавсаргав.

Арван долоо. Хязгаарлалттай санал дүгнэлт

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлангаар дараах зөрчил илэрсэн нь санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд,

- 2015 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй,
- Норм, нормативын сангийн санхүүжилтийн урьдчилж гарсан зардал 576.6 сая төгрөгийг жилийн санхүүгийн тайлан гарахаас өмнө тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Техник хяналтын зардлын 900029301 дугаар данснаас 27.0 сая төгрөгийг анхан шатны зохих баримтгүйгээр Барилгын хөгжлийн төв руу шилжүүлж зардлаар бүртгэсэн,
- Кассаас гарсан бэлэн мөнгөний 18.8 сая төгрөгийн зардлын гүйлгээний анхан шатны баримт дутуу буюу хүчин төгөлдөр бус байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, 13 дугаар зүйлийн 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд

тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.2.6 ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах гэсэн заалтууд болон Үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэл зэрэгтэй тус тус нийцэхгүй байна.

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

АСУУДАЛ 1

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт

АСУУДАЛ 2

Урьдчилж төлсөн зардлын тооцоо

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН
2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллагын энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн шууд захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН
2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АСУУДАЛ 1: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт

Ажиглалт

2015 оны санхүүгийн тайлангийн касс, харилцахын гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд 4.4 сая төгрөгийн анхан шатны баримтгүй гүйлгээ, ажил гүйцэтгэх гэрээгүй, ажил хүлээлцсэн актгүй 5.0 сая төгрөгийн гүйлгээ, кассаас гарсан бэлэн мөнгөний 18.8 сая төгрөгийн зардлын гүйлгээний анхан шатны баримт дутуу буюу хүчин төгөлдөр бус байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж заасныг мөрдөж ажиллах

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, санхүүгийн хяналт сулрах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно



БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН
2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АСУУДАЛ 2: Урьдчилж төлсөн зардлын тооцоо

Ажиглалт

Норм, нормативын сангийн санхүүжилтийг БХБЯ-наас Барилгын хөгжлийн төвд шилжүүлдэг бөгөөд 2015 оны санхүүгийн тайланд 576.6 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын тооцоо тайлагнадсан боловч жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг биелүүлж ажиллах

Эрсдэл

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2016.02.24 № 3/211
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Барилга хот байгуулалтын яамны аппаратын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлангаар дараах зөрчил илэрсэн нь санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд,

- 2015 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй,
- Норм, нормативын сангийн санхүүжилтийн урьдчилж гарсан зардал 576.6 сая төгрөгийг жилийн санхүүгийн тайлан гарахаас өмнө тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Техник хяналтын зардлын 900029301 дугаар данснаас 27.0 сая төгрөгийг анхан шатны зохих баримтгүйгээр Барилгын хөгжлийн төв руу шилжүүлж зардлаар бүртгэсэн,
- Кассаас гарсан бэлэн мөнгөний 18.8 сая төгрөгийн зардлын гүйлгээний анхан шатны баримт дутуу буюу хүчин төгөлдөр бус байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, 13 дугаар зүйлийн 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.2.6 ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтуудыг болон Үнэн зөв байх батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	2,688,678.00
2	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	2,688,678.00
3	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	0.00	-
10	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	345,263,770.40	576,599,420.40
12	Урьдчилж гарсан зардал	345,263,770.40	576,599,420.40
13	БАРАА МАТЕРИАЛ	42,607,143.55	11,999,314.60
17	Хангамжийн материал	42,607,143.55	11,371,814.60
19	Бусад	-	627,500.00
21	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	387,870,913.95	591,287,413.00
22	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	516,794,781.87	415,515,092.50
24	Биет хөрөнгө	503,242,331.84	406,952,342.50
27	Авто тээврийн хэрэгсэл	375,790,000.00	418,039,080.83
28	Хуримтлагдсан элэгдэл	(145,895,138.76)	(240,765,886.31)
29	Машин, тоног төхөөрөмж	452,644,674.46	467,825,967.17
30	Хуримтлагдсан элэгдэл	(245,685,689.03)	(319,034,895.75)
31	Тавилга, аж ахуйн эд хогшил	308,975,451.51	279,161,493.55
32	Хуримтлагдсан элэгдэл	(243,182,600.29)	(198,618,611.46)
39	Бусад үндсэн хөрөнгө	8,480,148.00	7,505,408.00
40	Хуримтлагдсан элэгдэл	(7,884,514.05)	(7,160,213.53)
42	Биет бус хөрөнгө	13,552,450.03	8,562,750.00
43	Програм хангамж	19,971,610.00	16,153,510.00
44	Хасагдуулга	(8,762,909.97)	(8,809,510.00)
45	Бусад	4,500,000.00	4,500,000.00
46	Хасагдуулга	(2,156,250.00)	(3,281,250.00)
48	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	516,794,781.87	415,515,092.50
49	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	904,665,695.82	1,006,802,505.50
50	Богино хугацаат өр төлбөр	-	4,966,790.00
51	Өглөг	-	4,966,790.00
52	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	4,247,690.00
57	Бусад өглөг	-	719,100.00
61	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	4,966,790.00
64	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	4,966,790.00
65	Засгийн газрын оруулсан капитал	324,390,884.93	324,390,884.93
66	Өмнөх үеийн үр дүн	580,274,810.89	580,274,810.89
67	Тайлант үеийн үр дүн	-	97,170,019.68
69	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	904,665,695.82	1,001,835,715.50
70	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	904,665,695.82	1,006,802,505.50

Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,590,462,651.00	2,382,911,512.10
2	Улсын төсвөөс	2,590,391,500.00	2,377,477,470.00
3	Урсгал	2,590,391,500.00	2,377,477,470.00
7	Нийгмийн даатгалын сангаас	71,151.00	-
10	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,434,042.10
15	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,627,100.00
16	Төсвийн урамшуулал	-	806,942.10
18	Бараа, үйлчилгээний орлого	748,200.00	73,808,420.15
20	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	748,200.00	73,808,420.15
22	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	748,200.00	14,678.00
24	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	73,793,742.15
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,591,210,851.00	2,456,719,932.25
27	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,866,169,598.25	2,172,703,123.60
28	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	1,084,907,005.00	1,033,445,756.28
29	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	975,804,024.00	931,422,156.28
30	Цалин	971,404,024.00	931,022,156.28
31	Нэмэгдэл цалин	4,400,000.00	-
34	Гэрээтийн цалин	-	400,000.00
35	Нийгмийн хамгааллын шимтгэл	109,102,981.00	102,023,600.00
36	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	89,565,862.00	83,134,557.00
37	Тэтгэврийн даатгалын шимтгэл	69,802,681.00	64,257,817.00
38	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,072,533.00	7,603,056.00
39	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,856,612.00	9,398,221.00
40	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,834,036.00	1,875,463.00
41	Эрүүл мэндийн даатгалын хураамж	19,537,119.00	18,889,043.00
42	Тогтмол зардал	46,703,770.00	10,706,200.00
43	Гэрэл цахилгааны зардал	18,046,010.00	-
44	Түлш, халаалтын зардал	25,907,060.00	-
45	Цэвэр, бохир усны зардал	2,750,700.00	-

**Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит**

46	Байрны түрээс	-	10,706,200.00
47	Хангамж, бараа материалын зардал	80,276,319.76	117,613,526.20
48	Бичиг хэргийн материал	19,720,378.00	39,676,090.00
49	Тээвэр, шатахууны зардал	27,669,881.56	15,361,523.00
50	Шуудан холбоо интернетийн төлбөр	18,206,990.20	17,112,643.20
51	Ном, хэвлэлийн зардал	616,300.00	338,000.00
53	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	-	32,784,870.00
55	Төлбөр хураамж	8,934,670.00	-
56	Биеийн тамир уралдаан тэмцээний	2,300,000.00	-
65	Урсгал засвар	2,828,100.00	12,340,400.00
66	Томилолт, зочны зардал	51,040,744.44	35,655,358.00
67	Гадаад томилолтын зардал	30,497,080.00	15,617,247.00
68	Дотоод томилолтын зардал	20,543,664.44	20,038,111.00
69	Гадаадын зочны зардал	607,700.00	4,204,801.00
70	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	81,728,976.00	278,549,550.65
71	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,979,876.00	274,148,450.65
73	Даатгалын үйлчилгээний төлбөр	3,449,100.00	3,775,800.00
74	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	625,300.00
80	Бараа үйлчилгээний бусад зардал	521,512,783.05	696,732,732.47
81	Бусад зардал	427,341,248.70	504,422,299.95
82	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,218,000.00	-
83	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,345,834.35	188,105,631.52
95	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,300,000.00	186,846,788.97
95	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	26,856,658.97
98	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,856,658.97
99	Бусад урсгал шилжүүлэг	8,300,000.00	159,990,130.00
101	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	546,470.00
102	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	111,505,234.00
105	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	24,074,850.00
107	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	8,300,000.00	23,863,576.00
122	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,874,469,598.25	2,359,549,912.57
123	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	716,741,252.75	97,170,019.68

**Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит**

124	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
128	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
129	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	0.00
132	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	0.00
133	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	716,741,252.75	97,170,019.68

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
3	2014 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл				
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
7	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
8	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
9	Тайлант үеийн үр дүн				
10					
11	2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	324,390,884.93		580,274,810.89	904,665,695.82
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93		580,274,810.89	904,665,695.82
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
15	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
17	Тайлант үеийн үр дүн			97,170,019.68	97,170,019.68
18	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	324,390,884.93		677,444,830.57	1,001,835,715.50

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Тусламж, санхүүжилтын орлого	1,352,182,953.00	2,382,911,512.10
2	Улсын төсвөөс	1,350,811,900.00	2,377,477,470.00
3	Урсгал	1,350,811,900.00	2,377,477,470.00
7	Нийгмийн даатгалын сангаас	1,371,053.00	-

**Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит**

10	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,434,042.10
15	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,627,100.00
16	Төсвийн урамшуулал	-	806,942.10
18	Бараа, үйлчилгээний орлого	144,000.00	733,778.00
20	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	144,000.00	733,778.00
22	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	733,778.00
25	Бусад орлого	144,000.00	-
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,352,326,953.00	2,383,645,290.10
28	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,135,361,176.90	2,178,148,146.13
29	Ажиллагчидтай холбогдсон зардал	511,640,838.00	1,029,198,066.28
30	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	460,918,041.38	927,174,466.28
31	Цалин	278,974,041.38	530,077,166.28
32	Нэмэгдэл	121,944,000.00	280,471,700.00
33	Унаа хоолны хөнгөлөлт	30,000,000.00	61,425,600.00
35	Гэрээтийн цалин	30,000,000.00	55,200,000.00
36	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	50,722,796.62	102,023,600.00
37	Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,722,796.62	102,023,600.00
42	Бараа үйлчилгээний урсгал зардал	623,720,338.90	1,148,950,079.85
43	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,330,000.00	11,390,200.00
44	Гэрэл цахилгааны зардал	9,420,700.00	-
45	Түлш, халаалтын зардал	16,350,800.00	-
46	Цэвэр, бохир усны зардал	1,558,500.00	-
47	Байрны түрээс	-	11,390,200.00
48	Хангамж, бараа материалын зардал	44,009,398.20	88,988,546.20
49	Бичиг хэрэг	8,677,108.00	23,466,050.00
50	Тээвэр, шатахуун	12,035,620.00	14,964,703.00
51	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,047,875.20	16,966,473.20
52	Ном, хэвлэл	-	927,300.00
54	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,062,525.00	32,664,020.00
55	Төлбөр хураамж	9,886,270.00	-

**Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит**

56	Биеийн тамирын уралдаан тэмцээний	2,300,000.00	-
61	Эд хогшил, урсгал засварын зардал	1,276,900.00	12,340,400.00
65	Урсгал засвар	1,276,900.00	12,340,400.00
66	Томилолт, зочны зардал	39,815,816.00	40,650,828.00
67	Гадаад албан томилолт	20,164,910.00	15,617,247.00
68	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,491,000.00	4,052,180.00
69	Дотоод албан томилолт	18,159,906.00	20,981,401.00
70	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,728,976.00	504,794,903.65
71	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	77,979,876.00	500,393,803.65
73	Даатгалын үйлчилгээ	3,449,100.00	3,775,800.00
74	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	625,300.00
80	Бараа үйлчилгээний бусад зардал	429,559,248.70	490,785,202.00
81	Бараа үйлчилгээний бусад зардал	427,341,248.70	490,785,202.00
82	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	2,218,000.00	-
93	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,300,000.00	189,776,265.97
94	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	26,856,658.97
97	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,856,658.97
98	Бусад урсгал шилжүүлэг	8,300,000.00	162,919,607.00
101	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	114,181,181.00
104	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	24,074,850.00
106	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	8,300,000.00	24,663,576.00
107	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	1,143,661,176.90	2,367,924,412.10
108	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	208,665,776.10	15,720,878.00
109	Хөрөнгийн орлого	-	-
116	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,079,090.00	13,032,200.00
117	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,079,090.00	13,032,200.00
124	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	29,079,090.00	13,032,200.00
125	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(29,079,090.00)	(13,032,200.00)
126	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
134	Засгийн газрын бондын үндсэн төлбөр	-	-

**Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит**

135	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	-	-
137	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	179,586,686.10	2,688,678.00
138	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
139	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	179,586,686.10	2,688,678.00

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,510,706,400.00	2,354,906,895.23	155,799,504.77	93.79
2	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,510,706,400.00	2,354,906,895.23	155,799,504.77	93.79
3	IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,510,706,400.00	2,354,906,895.23	155,799,504.77	93.79
4	Бараа, үйлчилгээний зардал	2,344,156,400.00	2,191,180,346.13	152,976,053.87	93.47
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	927,488,200.00	927,174,466.28	313,733.72	99.97
6	Үндсэн цалин	530,390,900.00	530,077,166.28	313,733.72	99.94
7	Нэмэгдэл цалин	280,471,700.00	280,471,700.00	-	100.00
8	Унаа, болон бусад нөхөн олговор	61,425,600.00	61,425,600.00	-	100.00
10	Гэрээтийн цалин	55,200,000.00	55,200,000.00	-	100.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,023,600.00	102,023,600.00	-	100.00
12	Тэтгэврийн даатгал	64,924,200.00	102,023,600.00	(37,099,400.00)	157.14
13	Тэтгэмжийн даатгал	7,419,900.00	-	7,419,900.00	-
14	ҮОМШӨ ний даатгал	9,274,900.00	-	9,274,900.00	-
15	Ажилгүйдлийн даатгал	1,854,900.00	-	1,854,900.00	-
16	Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	18,549,700.00	-	18,549,700.00	-
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,486,000.00	11,390,200.00	2,095,800.00	84.46
21	Байрны түрээс	13,486,000.00	11,390,200.00	2,095,800.00	84.46
22	Хангамж, бараа материалын зардал	120,970,600.00	102,020,746.20	18,949,853.80	84.34
23	Бичиг хэрэг	27,622,000.00	23,466,050.00	4,155,950.00	84.95
24	Тээвэр (шатахуун)	14,498,300.00	14,964,703.00	(466,403.00)	103.22
25	Шуудан холбоо	25,419,700.00	16,966,473.20	8,453,226.80	66.75
26	Ном хэвлэл авах	655,600.00	927,300.00	(271,700.00)	141.44
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	52,775,000.00	45,696,220.00	7,078,780.00	86.59

**Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит**

33	Эд хогшил худалдан авах	12,500,200.00	12,340,400.00	159,800.00	98.72
37	Урсгал засвар	12,500,200.00	12,340,400.00	159,800.00	98.72
38	Томилолт, зочны зардал	48,132,100.00	40,650,828.00	7,481,272.00	84.46
39	Гадаад албан томилолт	10,136,000.00	15,617,247.00	(5,481,247.00)	154.08
40	Дотоод албан томилолт	29,566,000.00	20,981,401.00	8,584,599.00	70.96
41	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,430,100.00	4,052,180.00	4,377,920.00	48.07
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	611,274,900.00	504,794,903.65	106,479,996.35	82.58
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,642,400.00	500,393,803.65	100,248,596.35	83.31
43	Даатгалын үйлчилгээ	5,000,000.00	3,775,800.00	1,224,200.00	75.52
44	Тээврийн хэрэгслийн татвар	720,000.00	625,300.00	94,700.00	86.85
45	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	-	100,000.00	-
46	Мэдээллийн технологийн зардал	4,812,500.00	-	4,812,500.00	-
50	Бараа үйлчилгээний бусад зардал	508,280,800.00	490,785,202.00	17,495,598.00	96.56
51	Бараа үйлчилгээний бусад зардал	508,280,800.00	490,785,202.00	17,495,598.00	96.56
56	ТАТААС	166,550,000.00	162,919,607.00	3,630,393.00	97.82
59	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	806,942.10	(806,942.10)	-
60	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	806,942.10	(806,942.10)	-
63	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	806,942.10	(806,942.10)	-
63	Бусад урсгал шилжүүлэг	166,550,000.00	162,919,607.00	3,630,393.00	97.82
66	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	140,328,100.00	114,181,181.00	26,146,919.00	81.37
69	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,221,900.00	24,074,850.00	2,147,050.00	91.81
71	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	24,663,576.00	(24,663,576.00)	-
87	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,510,706,400.00	2,357,595,573.23	153,110,826.77	93.90
93	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	733,778.00	(733,778.00)	-
97	Төсвөөс санхүүжих	2,510,706,400.00	2,351,427,753.13	159,278,646.87	93.66
101	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,627,100.00	(4,627,100.00)	-
102	Төсвийн урамшуулал	-	806,942.10	(806,942.10)	-
104	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
105	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,688,678.00	(2,688,678.00)	-
106	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-

Барилга хот байгуулалтын яамны аппаратын
2015 оны санхүүгийн тайлангийн аудит

107	АЖИЛЛАГСАД БҮГД	64.00	64.00	-	100.00
108	Удирдах ажилтан	12.00	12.00	-	100.00
109	Гүйцэтгэх ажилтан	45.00	45.00	-	100.00
110	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
111	СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	-	-	-	-
112	Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад	-	-	-	-



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
М.БОЛОРТУЯА ТАНАА

2016.02.25 № 1/12

Зөрчлийг арилгуулах тухай

Барилга хот байгуулалтын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Техник хяналтын зардлын 900029301 дугаар данснаас 27,011,080 төгрөгийг зохих анхан шатны баримтын бүрдэлгүй Барилгын хөгжлийн төв руу шилжүүлж зардлаар бүртгэсэн,
- Мөн тус данснаас гарсан томилолтын зардлын 1,225,000 төгрөгийн баримт нь хүчин төгөлдөр бус байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгч байна.

1. Аппаратын үйл ажиллагааны хүрээнд гарсан томилолтын зардал болон бэлэн мөнгөний аливаа гүйлгээ, хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж баталгаажуулж хэвших, анхан шатны баримтгүй ямар нэгэн санхүүгийн гүйлгээ хийхгүй байх, зөрчил гаргасан холбогдох ажилтануудад хариуцлага тооцож ажиллах, дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх.
2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтуудыг баримтлан ажиллах.

Албан шаардлагын биелэлтийг 2016 оны 4 дүгээр сарын 25-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч М.Болортуяа, Ерөнхий нягтлан бодогч Т.Батчимэг нарт хариуцуулав.

АУДИТОР

Ж.БОЛОРМАА